



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.01.31, ПҮРЭВ ~ №021 (1073)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Өвөл, хаврын улиралд хурдан морины уралдааныг хориглолоо

Өнгөрсөн өвөл, хавар зургаан аймаг, 13 суманд хурдан морины уралдаан болжээ. >2

Хар дарсан зүүдний үргэлжлэл

ЭСЯ-аа орхиж би дүрвэхгүй ээ, ЭСЯ-аа манаад үлдэнэ гэдгээ ч эцэст нь хэллээ. >4

Д.Ганхуяг: Нийт хэрэглээний 20-30 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах боломжтой

Үйлдвэрлэсэн эрчим хүчээ нөөцлөх шийдэл цаг хугацааны л асуудал. >11

FULL ENGLISH PAGE INSIDE

ZGM DAILY >7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
ЗГ соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаар Д.Дулмааг тодруулж, 730 саяар шагнав. **НӨАТ-ын буцаан олголтыг** өнөөдөр, маргааш олгоно гэж Сангийн сайд мэдэгдлээ. **Өнөөдөр МАН-ын Удирдах** зөвлөлөөс УИХ-ын даргад нэр дэвшигчийг тодруулна. **С.Амарсайхан ажлаа хийхгүй** байгаа НИТХ-ын төлөөлөгчдийг зарлана гэв.

ЭДИЙН ЗАСАГ
Нийслэлд 2018 онд 60.5 мянган айлын орон сууцны 418 төсөл хэрэгжжээ. **Хөдөө аж ахуйн бирж 2018** онд 711.4 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна. **Intel Израилд 11 тэрбум** ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ. **Топ 20 индекс 0.65 хувиар** өсөж, 21630.39 нэгжид хүрэв.



НИЙГЭМ
Нийтийн тээвэрт 1,200, хүүхэд тээвэрлэх зорилгатаар 250 автобус нэвтрүүлнэ. **Зүүн баян дахь 336 дугаар** ангийн захирагч, хурандаа Д.Өлзийбаярыг чөлөөлжээ. **Хөрөнгө орлогоо худал мэдүүлсэн** нийслэлийн төрийн захиргааны албан хаагчдыг ажлаас халав. **Шинийн 4-ний баасан** гарагийн ажлын өдрийг ирэх бямба гараг руу шилжүүлжээ.

ДЭЛХИЙ
Мөнгөний ханш унасан улсуудад iPhone-ы үнийг хямдруулахаар Тим Кук амлаж байна. **АНУ-ын Техас муж улсад** цөмийн цэнэгт байлдааны хошууны үйлдвэрлэл эхэллээ. **Японы бүрэн эрх маргаантай** арлуудад хүчин төгөлдөр хэмээн Шинзо Абэ мэдэгдлээ. **Хурд 16 километр/цагаар** хэтрүүлсэн Британийн парламентын гишүүнийг шоронд хорив.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2018.01.31

☁️ | ☁️

-9° | **-22°**

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУГУУС УНШИНА УУ!

846 58 000 0 29112 01073

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©



МОНГОЛЧУУДАЙ БОЛГООМЖТОЙ ТҮНШЛЭХИЙГ ДИПЛОМАТУУД НЬ АНХААРУУЛАХ БОЛОВ



Хамтарч ажиллахад хамгийн ээдрээтэй, хэлсэндээ хүрдэггүй орны нэгээр Монгол Улс тодорч, олон улсад нэр нүүрээ барж байна. Хөрөнгө оруулалт татах чадвар маань бусад улстай харьцуулахад сул гэсэн үнэлгээ авч, Монгол Улсын шүүх засаглал гэрээний эрх зүйд олон улсын хөрөнгө оруулагчид эргэлзэж байгаагаа нуусангүй. >3

УЛС ТӨР УИХ сонгосон боллоо, утаа хэвээрээ л үлдэх нь

Г.Билүүн
ЗГМ

тушаалтан зэрэг 70 гаруй хүн оролцов. Хурлын эхэнд байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир зохион байгуулах дэгийг танилцуулж, зөвхөн УИХ-ын гишүүд л оролцогчдоос асуулт асууж хариулт авах эрхтэй хэмээв. Хурлыг санаачлагч Ерөнхийлөгчийн зүгээс ч асуулт асуух эрхгүй дэг тогтоосон нь үнэн чанартаа “хуваарилалт нь шог” гэдэг шиг болов. Мөн иргэдийн төлөөлөл гэх ганц хүн сууж байгаа нь ерөнхий сонголлыг зорилгоосоо хазайсан ердийн нэг хурал болголоо. >2

ЭДИЙН ЗАСАГ Идэвхгүй үнэт цаасыг биржийн бүртгэлээс хасна

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

биржийг хялбаршуулж ойлговол ердөө л дэлгүүр. Дэлгүүрийн лангуу сүүлийн жилүүдэд шинэ бараагаар төрөлжиж, бүтээгдэхүүний сонголт нь нэмэгдэж байна. Хаалттай байсан компаниуд нээлттэй хэлбэрт шилжиж, гэр бүлийн мэдлээ олон нийтийн өмчлөл рүү хөрвүүлж эхэллээ. Ингэснээр шаардлагатай хөрөнгө оруулалтаа дан ганц банкны зээл, компанийн өөрийн хуримтлалаар бус IPO хийх буюу иргэдэд хувьцаагаа санал болгох замаар шийдэх болов. >12

ЗГМ: ИНФОГРАФИК

МОНГОЛ УЛСЫН 100 БА ТҮҮНЭЭ ДЭЭШ НАСТАН

Монгол Улсын хэмжээнд 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 100 ба түүнээс дээш настай 116 хүн энх тунх амьдарч байна.

51 Улаанбаатар | 65 Орон нутаг

Монгол Улсын өндөр настай иргэд, нас, хүйсээр

112	1
110	1
108	1
107	2
106	1
105	5
104	5
103	6
102	13
101	22
100	45

12.1% | 87.9%

Монгол Улсын өндөр настай иргэд, үндэс угсаагаар

93	Халх	Дарьганга	2
11	Казах	Баяд	2
2	Дөрвөд	Захчин	1
2	Урианхай	Буриад	1
2	Хотгойд		

УСХО >5

ЗГМ: СЭДЭВ Хөдөлмөрийн хууль хөгжлөөс 20 жилээр хоцорлоо

Г.Байгал
@baigalZGM

Монголын хөгжлөөс 20 жил хоцорч буй хөдөлмөрийн хуулийн төсөл УИХ-ын хаалгыг тогшоод нэг жил болох гэж байна. Гэвч ажил хийж буй иргэн бүр хамаатай, манай улсын хамгийн үнэ цэнтэй баялаг болох монгол хүний хөдөлмөрийн харилцааг зохицуулах уг хуулийн төслийг анхаарах сэхээ, сөхөж үзэх сөхөө шийдвэр гаргагчдад байсангүй. Хүн хэмээх үнэт капиталын хөдөлмөрийн харилцаа шинэ зуунд хөсөр хаягдсан. Монгол Улс 1999 он буюу зах зээлийн замаар замнаад удаагүй, хагас их наяд төгрөг ч хүрдэггүй эдийн засагтай байхдаа Хөдөлмөрийн тухай хуулиа шинэчилж байжээ. Үүнээс хойш Хөдөлмөрийн тухай хуулийг цогцоор нь хөндөлдгүй, нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох журмыг нь шинэчлэх зэргээр торгоосоор хоёр ч арван жилийг үржжээ. Гэтэл энэ хугацаанд манай улсын ДНБ-ий хэмжээ 150 дахин өсөж, аж ахуйн нэгжийн тоо бараг найм дахин нэмэгджээ. “Хөдөлмөрийн тухай хууль шилжилтийн үеийн хөдөлмөрийн харилцааг зохицуулахад өөрийн үүргээ хангалттай биелүүлсэн ч өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна” хэмээн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг мэдэгдсэн. >5

АЛТ 1313.84 0.16%	ЗЭС 6050 0.80%	10-ЧИНГИС БОНД 94.26 0.00%	ХУРАЛДАЙ БОНД 107.52 0.1%	ГЭРЭГЭ БОНД 95.63 0.16%	АМ.ДОЛЛАР 2929.69	ЮАНЬ 391.97	РУБЛЬ 39.78
--------------------------------	-----------------------------	---	--	--------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Нийтлэлчийн булан

Гэрээгээ мөрдөхгүй цагт хөрөнгө оруулагчид Монголоос зугтсаар байх нь

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Хөрөнгө оруулалтын орчны сайжруулна, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаална, хууль эрх зүйн актуудаа тогтвортой байлгана, татварын дарамтыг багасгана... эдгээр амлалтууд үнэ цэнээ бүр алдаж гүйцлээ. Үүнийг манай засаг төр тоть мэт байнга давтаж, үе үеийн сайд, дарга нар амны уншлага болгосон ч хэлсэн үгнийхээ эсрэг хийтэй үйлдэл гаргасаар ирсэн нь хөрөнгө оруулалт дайжихад хүргэж байна. Бидний үгэнд ч гаднын хөрөнгө оруулагч бүрэн дүүрэн итгэж чадахаа байж. Итгэл байхгүй бол бизнес өрнөхгүй, хамтарч ажиллаж чадахгүй.



Б.Хасуй / ЗГМ©

Төв банкны зарласан албан ханшаар ам.доллар лхагва гарагийн байдлаар 2629 төгрөгтэй тэнцэж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт хумигдсан жилүүдэд валютын орох урсгал татарч, ам.долларын эрэлт өсөж байлаа. Энэ хандлага одоо ч эдийн засагт хүчтэй хэвээр.

Монголчуудтай болгоомжтой түншлэхийг дипломатууд нь анхааруулах болов

Гаднын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг манай улс 2016 онд байгуулж, тэдний бизнест тулгарч буй хууль бус дарамт, шахалтыг хазаарлана гэж ам гарсан. Гэвч нөхцөл байдал үүнээс хойш өмнөхөөсөө дээрдэх бус улам дордож, хөрөнгө оруулалтын өртөг, зардал нэмэгдэж байна. Монголыг тойрох хямд мөнгөний урсгал бидэнтэй ялгаагүй хөгжиж яваа эдийн засгуудыг чиглэн шинэ боломжоор тэднийг тэтгэж, тэнд ажлын байр бий болгож, иргэдийнх нь амьжиргааг сайжруулж эхэллээ. Хамтарч ажиллахад хамгийн ээдрээтэй, хэлсэндээ хүрдэггүй орны нэгээр харин Монгол Улс тодорч, олон улсад нэр нүүрээ барж байна.

● **Хөрөнгө оруулалт татах чадвар маань бусад улстай харьцуулахад сул гэсэн үнэлгээ авч, Монгол Улсын шүүх засаглалд олон улсын хөрөнгө оруулагчид эргэлзэж байгаагаар нуусангүй.**

● **Гаднын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг манай улс 2016 онд байгуулж, тэдний бизнест тулгарч буй хууль бус дарамт, шахалтыг хазаарлана гэж ам гарсан.**

● **Хөрөнгө оруулалтын орчин муудахад нөлөөлж буй хоёр дахь хүчин зүйл нь гэрээний хэрэгжилт.**

Хөрөнгө оруулалт татах чадвар маань бусад улстай харьцуулахад сул гэсэн үнэлгээ авч, Монгол Улсын шүүх засаглалд олон улсын хөрөнгө оруулагчид эргэлзэж байгаагаар нуусангүй. Тиймээс монголчуудтай бизнес хийхийн тулд маргаан гарсан тохиолдолд түүнийг Улаанбаатарт бус Сингапур

аль эсвэл Лондоны шүүхээр шийдвэрлэх зохицуулалтыг заавал гэрээндээ суулгасан байх ёстойг хөрөнгө оруулагчид ях махаараа мэдэрч авчээ. Олон улсын хөндлөнгийн шүүхээр бизнесийн маргаанаа хагалж, өөрсдийн эрх ашгаа хамгаалуулах нь илүү цаг хугацаа, мөнгө хэмнэнэ гэж хөрөнгө оруулагчид үзэж байна.

“Монголд хөрөнгө оруулалт хийж, бизнесийн үйл ажиллагаа явуулахаар ирсэн өөрийн орны хөрөнгө оруулагчдад хандан гэрээндээ маргаан үүслээ гэхэд түүнийгээ заавал олон улсын шүүх, арбитрад мэдүүлэх хэрэгтэй гэж зөвлөдөг” тухайгаа Канад Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Дэвид Струп албан бусаар илэрхийлсэн юм. Ер нь гаднын орнуудаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдууд манай улсын хөрөнгө оруулалтын орчны эрсдэлийг маш өндөр гэж нэрлээд зогсохгүй гэрээний соёл бүрэн утгаараа хэрэгжиж чадахгүй байгаад эмзэглэж байгаагаа илэрхийлж буй. Элчин сайд Дэвид Струп “Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад шударга шүүх юу юунаас илүү чухал. Монгол Улсын хувьд шүүх засаглалын чанар чансааг илүү сайжруулах бодитой шинэчлэл, өөрчлөлт хийгээсэй гэж хүсдэг” тухайгаа манай сонинтой хуваалцсан юм.

Хөрөнгө оруулалтын орчин муудахад нөлөөлж буй хоёр дахь хүчин зүйл нь гэрээний хэрэгжилт. Байгуулсан гэрээгээ мөрддөггүй, гэрээгээр хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлдэггүй байдал хөрөнгө оруулалт хөрөнгө оруулагчтайгаа хамт манайхаас дүрвэх ээлжит шалтгаан болж байна. Ямар ч нөхцөлд гэрээгээ мөрдөж ажиллах нь хоёр талын үүрэг, хариуцлага атал байгуулсан гэрээгээ умартах муу соёлыг төр өөрөө түүчээлж, хөрөнгө оруулагчдыг айлган дарамтлах үзэгдэл нэг бус удаа гарч буй. Энэ байдал хөрөнгө оруулагчид хамгийн эмзэг хандаж байгаа төдийгүй цаашид монголчуудтай бизнесийн түнш байх боломжгүй гэсэн үг зарим нь унагахад хүргэж байна.

Сангийн дэд сайдын хэлснээр, энэ онд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос 13 хувиар өсөж, 1.9 тэрбум

ам.долларт хүрэх бөгөөд гадаад худалдааны эргэлт дөрвөн хувиар сайжирч, 14 тэрбум ам.доллар давахаар байгаа юм. Мөн гадаад валютын нөөц 28 хувиар нэмэгдэж, 4.1 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн тооцооллыг 2019 оны төсөвт зурагласан. Ийм өөдрөг төсөөллөөр хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэж харж байгаа боловч Засгийн газартай холбоотой маргаанууд шинээр орж ирэх хөрөнгө оруулагчдын хөлийг чөдөрлөж мэдэхээр.

Шударга шүүх засаглал нь хөрөнгө оруулалт татах чадварыг нэмдэг

Авлигын индексээр Монгол Улс 175 орноос 103-т эрэмбэлэгдэж, 2017 онтой харьцуулахад 16 байраар ухарсан байна. Эндээс авлига нэмэгдэж байна гэсэн дүгнэлтэд шууд хүрч болохоор. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл өмнө нь цаасаар санал, гомдол хүлээн авдаг байсан бол энэ оноос гомдлыг барагдуулах цахим системийг нэвтрүүлэхээр болсон нь нэг дэвшил. Мөн хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвийг энэ сард багтаан нээхээ мэдэгдсэн ч энэ нь одоогоор бодит ажил болж амжаагүй байна.

Монголбанкны мэдээлснээр, өнгөрсөн онд хөрөнгө оруулалт 2017 онтой харьцуулахад 30 гаруй хувиар нэмэгдсэн гэх. Гэхдээ үүний ард нөгөө л “Оюутолгой” төслийн хоёр дахь шатны хөрөнгө оруулалт буй. Өсөлтийн үлдсэн хэсэг нь ОУВС-гийн манай улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд хийсэн ам.долларын санхүүжилтээр тайлбарлагдана. Шинээр орж ирсэн хөрөнгө оруулагч, томоохон хөрөнгө оруулалт гээд дурдахаар тоо баримт маруухан. Бидний хувьд хөрөнгө оруулалт татахын тулд хамгийн наад захын соёл гэгдэх байгуулсан гэрээнийхээ өмнө өөрсдөө хариуцлагатай, ёс зүйтэй байх шаардлага хөрөнгө оруулагчдын зүгээс тавигдаж

байна. Хэрэв ингэж чадахгүй бол юун хөрөнгө оруулалт мөрөөдөх. Төв банкны зарласан албан ханшаар

ам.доллар лхагва гарагийн байдлаар 2629 төгрөгтэй тэнцэж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт хумигдсан

жилүүдэд валютын орох урсгал татарч, ам.долларын эрэлт өсөж байлаа. Энэ хандлага одоо ч эдийн засагт хүчтэй хэвээр. Импортын хэрэглээ давамгайлсан манай улсад валютын ханшийн өсөлт эдийн засгийн хүндрэл бий болгоод зогсохгүй иргэдийн хэрэглээг ч улам үнэтэй болгож орхидог. Тиймээс экспортын орлогод дан ганц найдахаас гадна эдийн засгийн өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтад найр тавих хэрэгцээ, шаардлага их байна. Ирэх жилүүдэд өндөр дүнтэй валютын зээлийн эргэн төлөлт биднийг хүлээж байгаа. Ийм нөхцөлд ам.доллар улам үнэтэй болох эрсдэл бидэнд байна. [ЗГМ]

ЭМГЭНЭЛ

Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн Цэдэвийн Дашдорж мөнх тэнгэрт хальж, монгол түмэнд хүнд үй гашуу тохиолоо.

Цэдэвийн Дашдорж нь 1985 онд Нийслэлийн 10 жилийн 12 дугаар дунд сургууль, 1990 онд Политехникийн дээд сургуулийг тус тус төгссөн. Өрөмдлөгийн технологич инженер мэргэжил эзэмшсэн.

Тэрээр 1990-1993 онд “Газрын тос” ХХК-д өрөмдлөгийн инженер, 1995-2000 онд “Их тэмүүлэл” ХХКомпанийн Ерөнхий захирлаар ажиллаж байжээ. Улмаар 2000-2004, 2008-2012, 2012-2016 онуудад Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож Монгол Улсын хууль тогтоох үйл ажиллагаанд нэр төртэйгөөр гар бие оролцсон юм. Үүний зэрэгцээ 2004-2008 онд Барилга, хот байгуулалтын дэд сайд, 2012 онд Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, 2016-2017 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар тус тус ажиллаж байлаа.

Тэрээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ажиллаж байх хугацаандаа Уурхайн дэргэд үүссэн овоолго, хаягдлыг дахин ашиглах зорилгоор 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, үүсмэл орд ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлсэн юм. Түүнчлэн уул уурхайн салбарын хөгжлийг шинэ шатанд гаргахаар төлөвлөн ашигт малтмалын орд газруудыг шинээр ашиглалтад оруулахаас гадна одоо ажиллаж байгаа үйлдвэрүүд дээр технологийн шинэчлэл хийх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд онцгой анхаарч ажиллахаас гадна салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, олборлолт, баяжуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, нөхөн сэргээлт, уурхайн хаалттай холбоотой харилцааг зохицуулахаар бие даасан “Уул уурхайн тухай” хуулийн төслийг санаачилжээ.

Ц.Дашдоржийн хөдөлмөр зүтгэлийг төрөөс үнэлж, 2006 онд Алтангадас одон, бусад ойн медалиудаар шагнажээ.

Эх орныхоо эдийн засаг, нийгэм ялангуяа зам тээвэр, уул уурхайн салбарын хөгжилд оруулсан түүний үнэтэй хувь нэмэр болоод бүтээлч төлөв томоотой, аливаа асуудалд нухацтай ноён нуруутай ханддаг түүний зан чанар Монголын ард түмний сэтгэлд мөнхөд дурсагдах болно.

Ум сайн амгалан болтугай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ,
УИХ-ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН Д.СУМБЯАБАЗАР,
Р.ЖИГЖИД, Д.ГАНХУЯГ,
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД**



Цэдэвийн Дашдорж
/ 1967-2019 /

ZGM DAILY

First-ever general hearing on air pollution control takes place

Deputy Auditor General discloses of six cases involving air pollution reduction actions.

Mongolia's export to Japan grows 88.6 percent since 2016

Value of exported goods remain 21 times lower than imports from Japan.

Cabinet resolves to open laboratories at border checkpoints

According to authorities, current border control lacks inspection on minerals transport.

Top 20 Index grows 0.65 percent, to 21,630.39 points

Market cap stands at MNT 2.46 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Cabinet approves the "Health Food-Healthy Mongolian" national program. About MNT 148 billion will be financed for the program until 2023.

US Department of Home Security includes Mongolia on the list of countries whose nationals are eligible to participate in the H-2 visa programs in 2019.

Head of the Parliamentary Standing Committee on Budget Chojilsuren Battogtokh meets the World Bank delegation headed by the Country Director for China, Mongolia, and Korea Bert Hofman. Sides exchanged views on the course of action for the next two years.

ECONOMY

MSE Tier I-listed firm MIK Holding JSC's 100 percent owned MIK OSSK LLC releases a USD 250 million worth bond with 9.75 percent interest rate and maturity of three years at an international financial market.

Top 20 Index grows 0.65 percent, to 21,630.39 points. MSE A Index rises 0.24 percent, to 9,869.45 points. MSE B Index falls 0.79 percent, to 8,550.16 points. Market cap stands at MNT 2.46 trillion.

SOCIETY

Cabinet announces 2019 as the year for Promoting Patriotic Purchase.

Horse racing banned in Winter and Spring.

12,000 public transportation and 250 electric buses to be added this year.

In accordance with the celebration of Lunar New Year, the Cabinet decides to shift the working schedules of February 8th to February 2nd.

Auditor turns to Prosecutor over air pollution-related cases



Chairman of the general hearing did not allow President or public representatives for inquiries when approving procedures.

Khasui.B / ZGM©

First-ever general hearing on air pollution takes place

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Under the initiatives of the President Battulga Khaltmaa, the first-ever general hearing on air pollution reduction measures was held yesterday, during which the

Deputy General Auditor Oyunbileg Sanjaadorj informs that a list of authorities responsible for misuse of air pollution budget has been submitted to the Prime Minister and related officials, and related cases on six private entities have been sent to the General Prosecutor.

At the meeting, MP Eldev-Ochir Lkhagvaа, who chaired the hearing, did not allow the President or public representatives for inquiries when approving the procedures, which led to criticisms that the hearing turned into a regular meeting of a standing committee.

The purpose of the hearing was to discuss the spendings of air pollution reduction activities and decide on firm solutions to tackle the issue. For instance, the President formed a research team to study the most efficient options to tackle air pollution in Ulaanbaatar last year. The team concluded that the best solution was to accommodate the 200,000 households living in ger districts to the currently available apartments for 110,000 households. Accordingly, the President has issued a request to ratify a housing policy that will allow no-interest loans

for ger district households.

As the initiator, the MPs allowed the President to address the hearing once, in which he remarked, "We all know the current situation of air pollution. We have to decide on solutions here. Rural development is one of the solutions to migration-driven air pollution. Not smogless stoves. We need firm actions."

Owing to the fact that both the President and public representations were silenced, the hearing continued with presentations on air pollution reduction actions. Ms. Oyunbileg criticized, "The

air pollution reduction actions since 1995 were non-correlated. Both foreign and national projects failed to show notable results. The distribution of enhanced stoves was inefficient. The stoves failed to perform as planned because of improper use. Results of discounted insulation remain vague due to the lack of studies on results. Same goes to the annulment of night-time electricity tariff. A research was conducted on air pollution reduction, but the results were not evaluated and the research was never used on any projects." [ZGM]

TRADE

Export to Japan rises 88 percent since EPA: Value remains 21 times lower than import

Since the Economic Partnership Agreement (EPA) of 2016, Mongolia's export to Japan surged by 88.6 percent in 2018; however, the value of exported goods remains 21 times lower than the import from Japan.

Compared to the same period of 2017, the value of goods jumped 78.6 percent to USD 26.4 million, which is only about 8.2 percent higher than 2014 when the commodity market was on a boom. Export to Japan sank to about USD 14 million by 2016 and slightly recovered in the following year.

As for imports, the growth stood at 54.5 percent year over year in

2018. The EPA was relatively fruitful for Japan as the value of imported goods hiked from USD 330 million in 2016 to USD 561 million last year.

Key export items to Japan include knit products, cashmere, towel, copper ores, concentrates, and aluminum goods with copper exports making up the majority. Additionally, Oyu Tolgoi LLC previously announced that the company has begun exporting copper ores to Japan.

As for imported goods from Japan, vehicles account for the majority. In specific, the overall passenger car imports grew by 31

percent last year, of which import from Japan comprised 86 percent of the total amount.

Mongolian National Chamber of Commerce and Industry (MNCCI) informed that over 10 items were granted certificates of origin in 2018 within the frames of the EPA. The MNCCI has highlighted that, despite the implementation of the EPA, the types and amount of export goods remain few.

In addition, private sector representatives have suggested to include several goods on the discounted list of items of the EPA, such as felt shoes, seabuckthorn and leather products. [ZGM]

POLITICS

Advanced border control system to be installed at main checkpoints

Cabinet decided to establish laboratories with cutting-edge equipment at the main export border checkpoints at its regular meeting yesterday. Authorities explained that these laboratories will help identify the quality, components, and quantities of export coal, copper and other goods, as well as deducting full

tax from them.

"In order to prevent smuggling and false registry of quantity, content, and quality, step-by-step measures will be taken to install x-rays and other monitoring systems at the border checkpoints and customs," stated the Cabinet.

As of today, only about 3.3 percent of goods are inspected

via x-rays or other equipment and the rest are checked in person. Although mining goods are examined via security cameras, the customs officers are unable to inspect them at the border. In other words, the customs authority currently lacks the ability to detect smuggling when it is hidden under the minerals. [ZGM]

ZGM: INFOGRAPHICS

Foreign direct investment to Mongolia in 2018

Investors suggest giving opportunities for private businesses to increase foreign direct investment (FDI) and focus on IT development. Furthermore, experts expect increased investment in Mongolia's agriculture and meat production and express tax, legal environment, and transparency as key issues for doing business in Mongolia.



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.0.31 ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Тусгай зориулалтын хаалт нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: МС-27/2019

"ДЦС-4" ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос "Тусгай зориулалтын хаалт" нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.,2017, 2018 он тус бүрээр

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2017,2018 тус бүрээр /ноглох баримтын хамт/ сүүлийн 2 жилийн дүн Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна. Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгаа хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2019 оны .03. дугаар сарын .05. -ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 03 дугаар сарын 05 -ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, "ДЦС-4" ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-13097000-1357

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

07.00	Өглөө хөтөлбөр
10.00	Прокурорын цаг
11.00	"Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр / шууд/
19.10	Зан үйлийн утгын тайлал: "Цагаалах ёс"
21.15	Монголын түүх: "Юань гүрэн"
22.20	"Цагаан боол" ОАУСК 42-р анги
Bloomberg TV Mongolia	
09.00	"Бизнесийн хэмнэл" хөтөлбөр
11.00	"Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг
14.00	"Давос" тусгай хөтөлбөр
15.00	"Бизнесийн төв цэг" хөтөлбөр
21.00	"Мөнгөний урсгал" хөтөлбөр
22.00	"Дэвид Рубенштэйний шоу" нэвтрүүлэг
БОЛОВСРОЛ HD	
07.05	"Бяцхан оцон шувуу Пороро" хүүхэддэйн кино 5.19-22-р анги
09.00	"Шидтэнүүдийн клуб" хүүхэддэйн кино 6.9-10-р анги
12.10	"Да Винчи ба Митрагийн тайлаглашгүй нууцууд" ОАК 1.6-р анги
15.00	Хятад хэлний хичээл анхан дунд №38,39
20.40	"Миний мэргэжил" хөрөг нэвтрүүлэг
21.10	"Аяыг таа" шоу нэвтрүүлэг
МОНГОЛ TV	
07.00	Өнөө өглөө
12.00	Хөтөч мэдээллийн хөтөлбөр
13.30	"Ан амьтдын ертөнцөөр" /season-8/ 10-р хэсэг
18.30	"Тог тог тог" /season-7/ 24-р хэсэг
21.00	"Төрөх өрөөний тоглоом" /season-2/ 11-р хэсэг
22.30	"Хуурай эгч дүүс" СОАК 4-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 26
Өвлийн адаг хөхөгчин үхэр сарын зургаан цагаан мэнгэтэй шар луу өдөр
Үс засуулбал: Жаргал үргэлжид ирнэ
Наран ургах, шингэх: 08.19-17.50
Барилдлага: Ул тохирох
Шүтэн барилдлага: Нэр өнгө
Суудал: Ус

Аргын тооллын нэгдүгээр сарын 31, Бархасвадь гараг. Билгийн тооллын 26, Эрхтэний тэнгэрт одтой, шар луу өдөр.
Өдрийн наран 08.19 цагт мандан, 17.50 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхтох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхтох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн зүгт мөрөө гаргавал зохиштой. Үс шинээр үргэлжлэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.



"Эх ундарга" язгуур урлагийн тоглолт
Хаана: Corporate Convention Centre
Хэзээ: 2019.02.01-ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 35 мянга



"Хунт нуур" бүжгэн жүжиг
Хэзээ: 2019.02.02-ны 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮ 10-30 мянга



Хип хоп хамтлагуудын "Мандан бадраг" тоглолт
Хаана: Corporate Convention Centre
Хэзээ: 2019.02.06-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 50 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР



"Соёлын довтолгоо" өрнөлөө

1959 он. Улс орон даяар "Соёлын довтолгоо" өрнүүлэх тогтоол гарлаа. Бүх нийтээр соёлжиг, усанд орох, дотуур хувцас хэрэглэх, шүдээ угаах зэрэг наад захын дадал сууж, хүмүүс ариун цэвэрч байдлыг эрхэмлэх хэрэгтэй болов. Энэхүү

"Соёлын довтолгоо"-г хэрэгжүүлэх үүрэгтэй ариун цэврийн байцаагч Далхаа нэгэн суманд ирснээр үйл явдал өрнөнө. "Маск" продакшны дэлгэцийн хоёр дахь бүтээл "Соёлын довтолгоо" уран сайхны кино нэгдүгээр

сарын 19-нөөс кино театрууд болон Corporate Convention Centre-ийн дэлгэцнээ гарч эхэллээ. Киноны найруулагчаар Д.Мөнхбат ажиллаж, М.Баярмагнай, Ж.Мөнхсайхан нар гол дүрд нь тогложээ. [ЗГМ]

ЦАГ АГААР




ФОТО АГШИН



Эхнэрээ эсэн мэнд амаржихыг хүссэн залуус энэхүү хөшөөнд хүслээ шивнэдэг уламжлал нэгэнт тогтжээ. С.Батсайхан / ЗГМ ©

ЗГМ: ҮГИЙН СУЛЖЭЭ

1	2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23	24

спортын төрөл
18. Эпшиг
19. Бурханы гэргий

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Тэнгэрийн өнгө
3. МАНАН-гийн толгойлогч гэгдсэн улстөрч
7. Хамгийн олон хүн амтай тив
9. Дэлхийн хамгийн урт мөрөн гол
10. Туялзуур жад
12. Бууны эд анги
14. Монголд анхны олимпын аваргыг төрүүлсэн

тоглодог тоглоом
16. Буриадын нэгэн овог
17. "Үхэрчин хүү" дууг зохиосон нэрт соён гэгээрүүлэгч Баатар ван
20. Дэлхийн топ багуудад

тоглон гялалзаж асан алдарт хөлбөмбөгчин, өдгөө Либерти улсын Ерөнхийлөгч
21. Зэллэн ургах жимст ургамлын нийтлэг нэр

Өмнөх дугаарын хариу / 01.30

Ш	У	У	Р	Г	А	Э	Н	Х	Б	А	Т	
Н	Р	О	Г	Я	А	А	А	А	А	А	А	
У	Л	А	А	Н	Ц	У	Т	Г	А	Л	А	Н
			Н	Ж	У	Т	Д					
Б	У	Х	Н	О	О	Л	О	Л	Д	О	О	Н
У	А	О	Ь	А	Р	Э						
Д	Е	С	А	Н	Т	А	Н	У	Ж	И	Н	

ЗГМ: СУДОКУ

			9	8	4	
		6				
8	1	3				
6	4	3				
	3		2	7	6	
	8					
3	9			6	4	7
7	6					5
			5			

7	4	1	2	3	8	9	6	5
2	3	5	7	9	6	4	1	8
8	6	9	4	1	5	3	2	7
1	7	6	9	2	3	8	5	4
9	5	8	6	7	4	1	3	2
4	2	3	8	5	1	7	9	6
6	9	7	1	4	2	5	8	3
5	1	2	3	8	7	6	4	9
3	8	4	5	6	9	2	7	1

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ


ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ


УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ХӨХ ХОТ	10.30	12.00
ХӨХ ХОТ-УБ	13.00	14.40
УБ-ЭРХҮҮ	06.20	07.20
ЭРХҮҮ-УБ	08.20	09.20

ЭДИЙН ЗАСАГ

Америк анхааруулга: Huawei-гийн 5G-д бүү итгэ
АНУ Huawei-г "шившиглэн гутаах"-аар оролдож байна хэмээн БНХАУ үзэж байна. >10



Арван жилийн шийдвэр - Boeing 797
Дундын зайн хэмнэлттэй онгоц нь холын зайн хямд нислэг эрхлэгч компаниуд үүсгэж болзошгүй. >10



Арван жилийн шийдвэр - Boeing 797
Дундын зайн хэмнэлттэй онгоц нь холын зайн хямд нислэг эрхлэгч компаниуд үүсгэж болзошгүй. >10



Худалдааны дайныг эцэслэх найдвар байгааг Мнучин ойлгуулав

Салеха Мосин
БНХАУ худалдааны асуудлаар Ерөнхийлөгч Дональд Трампд ахиу буулт хийх тохиолдолд Цагаан ордон бүх тарифыг цуцалж ч болзошгүйг АНУ-ын Сангийн сайд Стивен Мнучин мэдэгдлээ. "Бүх асуудлыг тохиролцоо боломж бий" хэмээн Мнучин мягмар гарагт Fox Business Network-д өгсөн ярилцлагынхаа үеэр мэдэгдэв. Сангийн сайд АНУ-ын Худалдааны төлөөлөгч Роберт Лайтнайзерын хамт Хятадын дээд албаны хүмүүстэй Вашингтонд яриа хэлэлцээ өрнүүлнэ. Энэ удаагийн яриа хэлэлцээ Цагаан

ордон БНХАУ-д шинэ тариф оноох замаар худалдааны дайнаа шатлан өргөжүүлэхээс сарын өмнө болж байна. Трамп, Ши нар БНХАУ-ын эдийн засгийн загварт "бүтцийн шинэчлэл" өрнүүлэх тохиролцоо хийх нэг сарын хугацааг албаны хүмүүстээ өгсөн юм. Тохиролцож чадахгүй бол эдүгээ 10 хувьтай байгаа Хятадын импортын бараа бүтээгдэхүүний тарифыг Трамп 25 хувь болгож өсгөхөөр сүрдүүлсэн. Яриа хэлэлцээ бүтэлгүйтэх нь дэлхийн эдийн засгийн дээр хуралдсан бараан үүлийг сарниах сүүдрийн найдварыг үгүй хийнэ.

Дотоодын эдийн засгийн өсөлт нь 2009 оноос хойш үнэмлэхүй суларсан Хятадын хувьд худалдааны маргааныг шийдвэрлэх нь тулгамдсан асуудал боллоо. Трампын худалдааны багийн гишүүдийн санал ч зөрөөтэй. Лайтнайзер, Үндэсний Худалдааны Зөвлөлийн (National Trade Council) захирал Питер Наварро тэргүүтэй харцагууд Хятадыг ахиу буулгах эрмэлзэлтэй. Мнучин, Цагаан ордны эдийн засгийн зөвлөх Ларри Кудлов нар АНУ-ын эдийн засгийн өсөлтийг тэргүүн зэрэгт тавих сонирхолтой.

Huawei Technologies компанийн эсрэг явуулж буй АНУ-ын үйл ажиллагаа худалдааны яриа хэлэлцээтэй холбоотой гэсэн цууг ноён Мнучин няцаалаа. АНУ-ын прокурорын байгууллага даваа гарагт Huawei-д эрүүгийн хэрэг үүсгэж, худалдааны нууц хулгайлсан, банкны луйвар явуулсан хэрэгт буруутгасан. Харин Мнучин уг хэргийг худалдааны хэлэлцээрээс тусдаа үйл явдал хэмээн тайлбарлав. Цагаан ордон яриа хэлэлцээг чухалд тооцож буйн тэмдэг болгон Дональд Трамп Хятадын талын гол тохиролцогчтой долоо хоногийн эцсээр уулзана

хэмээн таамаглаж байна. Хятадын эдийн засагт бүтцийн шинэчлэл өрнүүлэх Вашингтоны шаардлагатай уялдуулан яриа хэлэлцээний сүүлийн шатны гол сэдэв АНУ-ын бараа бүтээгдэхүүн ахиу худалдаж авах Бээжингийн амлалт байх юм. Европ, Хятадад эдийн засгийн өсөлт саарсныг ноён Мнучин хүлээн зөвшөөрдөг ч энэ нь АНУ-д нөлөөлөхгүй гэсэн бодолтой. "Эдийн засаг сулрах шинж тэмдэг одоогоор байхгүй" хэмээн сангийн сайд мэдэгдсэн. Хятадтай хийж буй худалдааны дайн АНУ-д хохируу учруулахгүйн зэрэгцээ "энэ онд

эдийн засаг гурван хувь өснө гэдэг маш сайн үзүүлэлт" хэмээн тайлбарлав. Харин нам бус, Конгрессын Төсвийн Хороо (Congressional Budget Office) даваа гарагт АНУ-ын эдийн засгийн бараан зураглал гаргаж ирлээ. Төсвийн алдагдал ихсэж, эдийн засгийн өсөлт 2.3 хувьтай гарах төлөвтэйг тус хороо анхааруулав. Бүгд найрамдахчуудын татварын хөнгөлөлтийн ачаар 2018 онд үүссэн эдийн засгийн өсөлт ирэх хэдэн жилд саарахтай зэрэгцэн Трампын засаг захиргааны тариф эдийн засаг, бизнесийн итгэлийг сулруулна хэмээн төсвийн хороо үзэж байна.

Азийн насан өтөл тэрбумтнууд 125 тэрбумыг атгаж байна



Винас Фэн
Шинэ он Азийн тэргүүн баян хоёр ч айлд үй гашуутай эхэлсэн юм. Индонезид олон тэрбум ам.долларын эзэнт гүрэн босгохоосоо өмнө, наргил, дал модны тосны худалдаагаар бизнесийн гараагаа 15-тайдаа эхэлсэн Эка Тжипта Виджажа (Eka Tjipta Widjaja) бямба гарагт 98 насандаа таалал төгсөв. Гутлын наймаачнаас Филиппиний тэргүүн баян болсон Хенри Си түүнээс долоо хоногийн өмнө 94 насандаа бурхны оронд заларлаа. Энэ хоёр эрхмийн нийт хөрөнгө 16.5 тэрбум ам.доллар давдаг. Ер бусын их эд баялаг хуримтлуулахад хугацаа ордог болохоор дэлхийн хамгийн баян эрхмүүд хамгийн өтөл байх нь тохиолдлын хэрэг биш. Bloomberg-ийн тэрбумтны жагсаалтад багтдаг 500 эрхмийн 80 нь 80-аас дээш настнууд. Мөн 21 нь 90-ээс дээш насалсан өтөл хөгшид. Энэхүү 21-ийн найм нь нийт 125 тэрбум ам.долларын эд баялаг хуримтлуулсан Азийн тэрбумтнууд. Нас сүүдрээс үүдэн дэлхийн түүхнээ хамгийн их төвлөрсөн хөрөнгийн нэг бусдад шилжих нөхцөл бүрдэж байна. "Өв залгамжлуулах тухай

бодож суугаа айл олширсон"-ыг Хонконгийн шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Азийн удам дамжсан бизнес, энтрепренёр судалгааны Tanoto төвийн захирал Пэн Чянь тайлбарлав. "Азийн тэргүүн баячуудын дунд ирэх хэдэн жилээс хувийн капиталын менежментийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ эрс ихэснэ" хэмээн захирал үзэж байна. Тэрбумтан таалал төгсөхөд цаашдын өрнөл хоёрхон хувилбартай. Хөрөнгийг нь ёс журмын дагуу хуваана, эсвэл өв залгамжлагчдын хооронд үхэх сэхэхээ үзэх тэмцэл өрнөнө. Хенри Си эхнийхийг нь сонгосон бололтой. SM Investment Corp-ынхоо хувьцааг арваад жилийн тэртээ зургаан хүүхдэдээ хувааж, бүгдийг нь тэрбумтан болгосон тэрбээр нас эцэслэх үедээ 7.2 тэрбумын хөрөнгөтэй байв. Эдүгээ 97 настай Стэнли Хо 2011 онд айл гэрийн доторх хэрүүлийг зогсоохын тулд эд баялгийнхаа ихэнхийг эхнэрүүд, хүүхдүүдийнхээ дунд хуваасан. Гэсэн хэдий ч ууган охин Пэнси зэрэг Хо овогтын ам бүлийнхэн Макаогийн казиногийн эзэнт улсын эд баялгийн төлөө арав гаруй жил тэмцэлдсээр ирлээ.

Хүнд жилийг үдсэн Apple-ын тайлан сайжрах талдаа орлоо

Марк Гурман
Хүнд хэцүү 2018 оныг давсан Apple-ын шинэ жилийн эхний улирал буюу санхүүгийн нэгдүгээр улирлын тайлан өөдрөг үзүүлэлттэй гарсан нь компанийн бизнес тогтворжиж буйн илрэл боллоо. Apple iPhone-ын борлуулалт муудсан ч үйлчилгээ, зүүж хэрэглэн төхөөрөмж зэрэг бусад бизнесийн орлого жилийн өмнөх үеэс өссөн дүнтэй гарав. Санхүүгийн хоёрдугаар улирал буюу 1-ээс 3 дугаар сард 55 тэрбумаас 59 тэрбум ам.долларын орлоготой ажиллана хэмээн Купертиногийн компани тооцоолж байна.

Энэтхэгийн нарны эрчим хүчний үйлдвэрлэл буурлаа

Аниндя Упадия
Хятадын хямд импортын бүтээгдэхүүнээс дотоодын нарны эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдээ хамгаалах Энэтхэгийн хүчин чармайлт ялагдал хүлээлээ. Тус улс Хятад, Малайзын нарны зай хураагуур, модуль төхөөрөмжийн импортын татварыг хоёр жил 25 хувь болгон өсгөх шийдвэрийг 2018 онд гаргажээ. Гэвч зохицуулалтын улмаас компаниуд хэрэгжүүлж байсан төслүүдээ хоёр жилээр зогсоох юм уу зүүн өмнөд Азийн бусад улсын хямд импортоор орлуулдаг болсныг Энэтхэгийн нарны эрчим хүчний төхөөрөмж үйлдвэрлэгчдийн холбооны статистик батлав.

MIAT MONGOLIAN AIRLINES

ОСАКА ХОТ ШҮҮД НИСЛЭГ

7,8 сард ЛХАГВА, НЯМ ГАРАГ БҮР

11 333-999 | www.miat.com

Эдийн засаг



2018 он санхүүгийн зах зээлийн хувьд их тэлэлтийн жил байсан. Тэгвэл энэ он байр сууриа бататгах, тоон амжилтаа хадгалах жил болохоор байна.



Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга **Б.Лхагвасүрэн**

МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ДЭМЖИЖ АЖИЛЛАНА

-Бид өмнөх түүхээсээ суралцаж, түүнээсээ дандаа сургамж авах ёстой. Анхны IPO 2005 онд гарсан гэж үздэг. Үүнээс хойш 2016 он хүртэл шинээр 14 компани хувьцаагаа олон нийтэд санал болгож, хөрөнгийн зах зээлд орж ирсэн. Эдгээр компанийн мэдээлэл хөрөнгийн биржийн сайт дээр байгаа. Та бүхэн үүнийг сонирхож үзэх хэрэгтэй. Аливаа хөрөнгө оруулалт хийх тухай шийдвэр тухайн компанийн түүхэн үзүүлэлттэй холбоотой байдаг юм. Ийм учраас хөрөнгө оруулагчид үнд анхааралтай хандах ёстой. Бидний хувьд 2018 оны өсөлтөө энэ онд үргэлжлүүлэхээр зорьж байна. 2017 онд бид санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрөө гаргасан. Энэ хөтөлбөрөөсөө жил бүр хэрэгжүүлэх ажлаа, үндсэн чиглэлээ аваад явдаг. Бид 2019 онд үндсэн хоёр гол зорилт тавьсан. Нэгдүгээрт, хөрөнгийн зах зээлийн хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхжүүлж, хөрвөх чадварыг нэмэгдүүлнэ. Хоёр дугаарт нь хөрөнгө оруулалт, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжинэ. Зах зээлд зөвхөн IPO санал болгох бус санхүүжилтийн өөр төрлийн нэмэлт бүтээгдэхүүнийг бий болгох судалгааны ажлыг эхлүүлсэн. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгоход хорооны хувьд дэмжиж ажиллана.

С.Батсайхан / ЗГМ©

Идэвхгүй үнэт цаасыг биржийн бүртгэлээс хасна

Хоёрдогч зах зээлийн арилжааг эрчимжүүлэх жил


Санхүүгийн зохицуулах хорооноос мягмар гарагт өнгөрсөн оны санхүүгийн зах зээлийн ерөнхий тоймыг танилцуулж, нэг жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийг энэ үеэр мэдээлсэн юм. ДНБ-ий тав орчим хувьтай тэнцдэг байсан санхүүгийн зах зээлийн эзлэх жин гурав дахин нэмэгдэж, 16 хувьд хүрсэн байна. Үүнийг задалж харвал, үнэт цаасны зах зээлийн үнэлгээ ДНБ-ий есөн дунгээр нийт 210.3 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа 2018 онд хийгджээ. Ингэснээр хөрвөх чадварын үзүүлэлт 2017 оныхоос 5.2 хувиар огцом нэмэгдсэн байна. Дэлхийн банк, ОУВС аливаа улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг үндсэн гурван үзүүлэлтээр голлон хэмждэг. Үүний нэг нь хувьцааны хөрвөх чадвар билээ. Тогтоол ус шиг таван хувиас хэтэрдэггүй байсан санхүүгийн зах зээл ийнхүү "сав"-аа томруулж байна. Хөрөнгийн зах зээлийг

сонирхох иргэдийн оролцоо, хандлага ч 2018 оны турш нэмэгдсэн байна. Тухайлбал, 2018 онд арилжаа 2.7 дахин өсөж, данс эзэмшигчийн тоо 400 мянгыг давжээ. Хөрвөх чадвар сайжрах хэрээр иргэд хоорондоо хувьцаагаа арилжаалах үйл явц сэргэсэн төдийгүй хоёрдогч зах зээл идэвхжсэн байна. Монголын хөрөнгийн зах зээл 2018 оныг чамлахааргүй арвин ургацтай үдсэн бол 2019 онд юу хүлээж байна вэ.

Хөрөнгийн биржийн зүгээс давхар бүртгэлийг энэ онд дахин үргэлжлүүлж, бүртгэлтэй гишүүн компаниудаа чанаржуулахад гол анхаарлыг хандуулахаар төлөвлөсөн аж.

Мөн компаниудын засаглалыг сайжруулахаас гадна үнэт цаасны арилжааг нь зогсоосноо хойш нэг жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй үнэт цаасыг биржийн бүртгэлээс хасах "ажиллагаа" хийгдэхээр байна. Үүний үр дүнд биржийн бараа, бүтээгдэхүүн тэр хэрээр хөрөнгө оруулагчдын анхаарал татна гэж үзжээ. Одоогийн байдлаар нэг жилээс дээш хугацаанд арилжаа нь зогссон, арилжаагаа сэргээх талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй нийт 29 компани байна.

Монголын хөрөнгийн биржийн Top 20 индексийн сагс энэ сарын



- **Монголын хөрөнгийн биржийн Top 20 индексийн сагс энэ сарын дундуур шинэчлэгдэж, өмнөх сагсанд багтаж байсан 11 компани хэвээр үлдсэн.**
- **Хөрөнгийн биржийн зүгээс давхар бүртгэлийг энэ онд дахин үргэлжлүүлж, бүртгэлтэй гишүүн компаниудаа чанаржуулахад гол анхаарлаа хандуулахаар төлөвлөжээ.**
- **Баялгийн хуваарилалтыг зөв хийдэг шалгарсан механизм нь хөрөнгийн зах.**

дундуур шинэчлэгдэж, өмнөх сагсанд багтаж байсан 11 компани хэвээр үлдсэн. Харин нэмж есөн компани шинээр дэвшин орж ирсэн билээ. 2018 он санхүүгийн зах зээлийн хувьд их тэлэлтийн жил байсан. Тэгвэл энэ он байр сууриа бататгах, тоон амжилтаа хадгалах жил болохоор байна. Оны анхны IPO болох "Түмэн шувуут" компанийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга үргэлжилж байна. Нийт 10 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлэхээр олон нийтэд хувьцаагаа санал болгож буй тус компанийн захиалга өнөөдөр өндөрлөх юм. Үүнийг залгаад сар шинийн дараа "Ард Кредит" банк бус санхүүгийн байгууллага IPO хийхээр бэлтгэлээ хангаж байгааг Санхүүгийн зохицуулах хороо мэдээллээ. [ЗГМ]



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга **Б.Өлзийбаяр**

ЗАХИРЛУУД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ НЭН ТЭРГҮҮНД БОДОХ ЁСТОЙ

-Сүүлийн үед хөрөнгийн зах зээлийн талаар хүмүүс маш идэвхтэй ярьдаг боллоо. Энэ зах зээл дэх иргэдийн оролцоо ч нэмэгдсэн. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ч тэр зах зээлтэй холбоотой мэдээ, мэдээлэл байнга гарч байна. IPO бол хөрөнгө босгох санхүүжилтийн нэг хэлбэр. Бүгдээрээ банк руу хошуураад байхгүй, хөрөнгийн зах зээл санхүүжилтийн өөр нэг боломжийг олгож байна. Компаниуд хувьцаагаа иргэдэд санал болгох замаар IPO эсвэл бонд гаргадаг. IPO хийж байгаа компанийн удирдлагууд яагаад IPO хийх гээд байгаагаа өөрсдөө дотроо шийдэж, зорилгоо тодорхой болгох ёстой. Үүнийг зөвхөн мөнгө гэж харах юм бол тэр IPO амжилттай болохгүй. IPO хийнэ гэдэг олон нийттэй өөрийн бизнесээ хуваалцаж байгаа хэрэг. Ийм нөхцөлд компанийн удирдлага өөрөө нээлттэй, компанийн мэдээлэл ил тод болгох хэрэгтэй. Хувийн компани удирдаж байгаа захирал шиг байж болохгүй. Олон нийтийн компани залж чиглүүлж байгаа тул хариуцлагатай, хувьцаа эзэмшигчдэдээ мэдээллийг нээлттэй хүргэж, шударга, ил тод зарчмаар явах учиртай. Энэ зарчмыг захирлууд дотроо хүлээн зөвшөөрөх ёстой. Гэр бүлийн компани байхдаа энэ зарчимд хариулж, өөрийгөө бэлтгэх хэрэгтэй.



Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга **Б.Ганбаяр**

ХӨРШ China Shenhua 2019 онд санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглана







Нүүрсний салбарт дэлхийд тэргүүлэгч China Shenhua компани 2019 онд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг хэрхэн ашиглах тухай төлөвлөгөөгөө танилцуулла. Тус компани юанийн

ханш болон ам.долларын бодлогын хүүгийн хэлбэлзлээс үүсэж байгаа эрсдэлээс сэргийлэхийн тулд ам.долларын бодлогын хүүгийн болон санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглахаар зорьж

байгаа талаар мэдээлсэн байна. Ингэхдээ хэмжээг нь тооцохдоо иен давамгайлсан өрийн ханшийн эрсдэлээс сэргийлэхийн тулд 32.2 тэрбум иенээ хэтрүүлэхгүй байхаар болжээ. Мөн одоогийн

ам.долларын өртэй холбоотой ханшийн эрсдэлээс сэргийлж, ам.долларын санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэмжээг 317 сая ам.доллараас хэтрүүлэхгүй байхаар тусгажээ. [ЗГМ]

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:



DOW JONES 3.29%	S&P 500 3.43%	FTSE 100 0.48%	NIKKEI 225 2.44%	TOPIX 2.82%	SHANGHAI COMPOSITE 0.72%	HANG SENG 0.82%	KOSPI 1.38%
---------------------------	-----------------------------	--------------------------	----------------------------	-----------------------	------------------------------------	---------------------------	-----------------------